



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар A/35

Мандалговь

Г Короновирусын халдвартын болзошгүй  
эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр  
авах арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн A/159 дугаар захирамж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны A/10 дугаар тушаал, 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/140 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ төрлийн коронавирусийн халдвартын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдыг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд ажлын цагийн хуваарийг 09:00-12:00, 14:00-17:00 цагаар тогтоож албан үүргийг гүйцэтгүүлсүгэй.

2. Ажилтан, албан хаагчдын ажилласан цагийг үндсэн цагаар ажилласанд тооцон цалинжуулахыг Нягтлан бодогч /С.Чинбат/-д зөвшөөрсүгэй.

3. Короновирусийн халдвартын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чанартай зохион байгуулан, мэргэжлийн байгууллагын зөвлөмж, халдварт хамгааллын дэглэмийг чанд сахиж, албаны бэлэн байдлыг хангаж ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн /Р.Мөнхбат/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



481190071